



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА САНДАГИЙН БЯМБАЦОГТ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвжавын САЙНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2026 04 09 № УИХ-03/3647
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Э.Болормаа, О.Саранчулуун, О.Номинчимэг, Ч.Номин, М.Энхцэцэг нар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



П.САЙНЗОРИГ

А.АРИУНЗАЯА

Х.БААСАНЖАРГАЛ

Б.БАЯРБААТАР

Э.БОЛОРМАА

О.САРАНЧУЛУУН

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

М.ЭНХЦЭЦЭГ

000000105



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
Пүрэвжавын САЙНЗОРИГ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
<http://www.parliament.mn>

2026 03 19 № УИХ-03/2713

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
тов тогтоолгох тухай

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, А.Ариунзаяа, Х.Баасанжаргал, Б.Баярбаатар, Э.Болормаа, О.Саранчулуун, О.Номинчимэг, Ч.Номин, М.Энхцэцэг нар Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, Хууль тогтоомжийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийнхээ хүрээнд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг санаачлан боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хянан үзэж Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх тов тогтоож өгнө үү.

Хавсралт 40 хуудастай.

Хүндэтгэсэн,

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН



П.САЙНЗОРИГ

А.АРИУНЗАЯА

Х.БААСАНЖАРГАЛ

Б.БАЯРБААТАР

Э.БОЛОРМАА

О.САРАНЧУЛУУН

Ч.НОМИН

О.НОМИНЧИМЭГ

М.ЭНХЦЭЦЭГ

000000091

**БАТЛАВ.
УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



П.САЙНЗОРИГ

2026 оны 03 дугаар сарын 16-ны өдөр

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон, тус хөтөлбөрийн 3.1.2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.” гэж, 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн 6.4-т “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2023 оны тоон мэдээллээс үзэхэд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас төрийн өмчит үйлдвэрийн газар 17 байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэргэжлийн байх, санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах, хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх зарчмыг хангах чухал бөгөөд дээрх зарчим нь төрийн өмчит үйлдвэрийн газарт үйлчлэх эсэх нь тодорхойгүй байна.

Нөгөөтээгүүр Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компани хэлбэрээр байгуулна.” гэж заасан бөгөөд төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох хуулийн зарчимтай.

Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуулийг зөрчиж тогтоосон нь тухайн төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үйлчилж байгаа бусад эрх зүйн зохицуулалтад хийдэл үүсэх шалтгаан болж, улмаар хууль хэрэглээний практикт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон хувийн хэвшлийн хуулийн этгээдэд ялгамжтай, тэгш бус хандах нөхцөлийг бүрдүүлж байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит компаниас гадна аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой, эсхүл улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд эдгээр үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх буюу компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байх хуулийн зохицуулалтыг бий болгох нь чухал байна.

Хуулийн төсөлд эдгээр үйлдвэрийн газруудаас ашгийн төлөө хуулийн этгээдийг компани хэлбэрт оруулж, цаашид үйлдвэрийн газар статустай хуулийн этгээд шинээр байгуулахгүй байхад чиглэнэ.

Цаашид төр, орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхийг ард түмнийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд энэхүү онцлог байдалд нь нийцсэн, ил тод, хяналттай, эдийн засгийг зохицуулагчийн чиг үүргээ хувьцаа эзэмшигчийн чиг үүргээсээ салангид хэрэгжүүлэх боломжийг олгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компани хариуцлага, эрх, үүргийн хувьд улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх, үр ашигтай байх, хараат бус хөндлөнгийн хяналттай байх, компанийн үйл ажиллагаа ил тод байх, компани төр, эсхүл орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх зарчмыг хуульчлах мөн шаардлага байна.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, олон улсын жишиг хандлагыг баримтлан компанийн сайн засаглалыг бүрдүүлэх шаардлагын үүднээс 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийн дагуу төрийн өмчит компанид бүрэн эрхт төлөөлөгч томилдог байдлыг халах нь зүйтэй байна.

Өөрөөр хэлбэл, төрийн болон орон нутгийн өмчит компанийг олон нийтийн болгох үйл ажиллагааг эрчимжүүлэн дэмжих нөхцөл бүрдүүлэх, үнэт цаасны зах зээл оролцогчийн хөрөнгө оруулалт, итгэлийг хамгаалах, төрийн өмчийг үнэгүйдүүлэхгүй байх, менежментийг ил тод, хариуцлагатай хийх зэрэг нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуультай зөрчилдсөн төрийн өмчит үйлдвэрийг газрын хэлбэрээр байгуулж байгааг халж, компани хэлбэрээр өөрчлөн байгуулах асуудлыг зохицуулна.

Хуулийн төсөл нь 2 зүйлтэй байна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэхэд түлхэц болохын зэрэгцээ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно.

Түүнчлэн хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлэх нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах боломжийг бүрдүүлнэ.

Дөрөв.Хуулийн төслийг батлахтай холбогдуулан цаашид шинээр боловсруулах, нэмэлт, өөрчлөлт оруулах хууль тогтоомжийн талаар

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенц болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай болон Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг дагалдуулан тус тус боловсруулна.

**1991 ОНЫ 01 ДҮГЭЭР САРЫН 04-НИЙ ӨДӨР БАТАЛСАН “БНМАУ-ЫН
ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ” ХУУЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД
ТООЦОХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА /ТӨВЧ/**

Өмчийн хэлбэрээр үл хамаарч аливаа компани нь төлөөлөн удирдах зөвлөлтэй, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн, хараат бус гишүүн нь ил тодоор сонгогдон хувь эзэмшигчдийн хурлаас томилогддог байх, ТУЗ-өөс ил тод, мерит зарчмаар гүйцэтгэх удирдлагыг томилдог байх, төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороо, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргатай байж компанийн сайн засаглалын хэрэгжүүлэх боломжтой байх ёстой.

Төрийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын жишгийн дагуу менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэх замаар төсвийн орлогыг нэмэгдүүлэх, үнэт цаасны зах зээлийг сэргээх, эрчимжүүлэх, ард иргэдэд оногдох өгөөжийг нэмэгдүүлэх зүй ёсны шаардалага манай улсад үүсээд байна.

Төрийн өмчит компанийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах, хувийн хэвшилтэй шударгаар өрсөлдөх нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Иймд төрийн өмчит компанийг засаглалыг сайжруулах, хариуцлага, ил тод байдал, санхүүгийн хүндрэлтэй байдлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай, Иргэний хууль, Компанийн тухай, Дампуурлын тухай хуулийн дагуу шийдвэрлэх боломжтой тул 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсрууллаа.

---oOo---



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
П.САЙНЗОРИГ НАР ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026. 01. 15 № ХЭГ/155
танай _____-ны № _____-т

Хуралдааны тэмдэглэл
хүргүүлэх тухай

Та бүхний санаачлан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн тэмдэглэлийг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт *Б* хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА



С.БЯМБАЦОГТ

000265000702

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 01 дүгээр сарын 07-ны өдрийн 1 дүгээр хуралдааны тэмдэглэлд:

“5.ХЭЛЭЛЦСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нараас санаачлан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Засгийн газраас өгөх санал, дүгнэлт

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг нараас санаачлан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд дараах санал, дүгнэлтийг хууль санаачлагч нарт уламжлахаар тогтов:

1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4, 5 дугаар зүйлд тус тус зааснаар төрийн өмчийг төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмч гэж ангилах бөгөөд төрийн өөрийн өмчид мөн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т зааснаар төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө буюу төрийн өмчит компанийн төрд ногдох хувь хөрөнгө хамаардаг.

Харин Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн хуулийн төсөл (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл)-ийн 7 дугаар зүйлд төрийн өмч нь төрийн нийтийн болон тусгайлсан өмчөөс бүрдэхээр, 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтад стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нь төрийн нийтийн өмч байхаар, 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахь заалтад стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаагаас бусад төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нь төрийн тусгайлсан өмч байхаар тус тус заасан.

Өөрөөр хэлбэл, төрийн өмчит компанийн эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарахгүй бөгөөд төр зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийн хүрээнд уг компанийн үйл ажиллагаанд оролцохоор тусгасан.

Харин Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өөрийн өмчийн төрлийн нэг болох Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан “төрийн өмчит үйлдвэрийн газарт” эзэмшүүлсэн эд хөрөнгө гэснийг “төрийн өмчит компанид” эзэмшүүлсэн эд хөрөнгө болгон өөрчлөхөөр тусгасан нь төр хувьцаа эзэмшигчээс гадна өмчлөгчийн хувьд төрийн өмчит компанийн эд хөрөнгийг удирдах боломжийг бүрдүүлж байх тул уг хэсгийг хасах;

2.Хуулийн төсөлд “улсын төсөвт үйлдвэрийн газар”, “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” зэрэг төрийн өмчит үйлдвэрийн газрын ангиллыг хуульчилсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг бүхэлд нь

хүчингүй болгохоор тусгасан боловч мөн хуулийн 16 дугаар зүйл “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх”, 17 дугаар зүйл “Улсын төсөвт үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх”, 18 дугаар зүйл “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргаа” гэсэн зохицуулалтыг хэвээр үлдээсэн байгааг анхаарах;

3.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн өмчит хуулийн этгээдийн ангилалд төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар хамаарахаар, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэж ойлгохоор тус тус заасан тул төрийн өмчит компани нь төрийн өмчит хуулийн этгээд бус харин төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болно.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13, 22 дугаар зүйлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал, тэдгээрийг байгуулах зохицуулалтад “төрийн өмчит компани” буюу төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг нэмэхээр тусгасан нь үндэслэлгүй байна;

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд төрийн өмчит үйлдвэрийн газрыг компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлэхээр тусгасан нь улс орныг хамарсан, нийгмийн хэрэгцээг хангах зорилготой, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит үйлдвэрийн газрууд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага үүсэж, төрөөс хүн, хуулийн этгээдэд чиглэсэн үйлчилгээнүүд төлбөртэй болох зэрэг эрсдэлтэй байна.

Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах” гэснийг “Төрийн өмчит үйлдвэрийн газрыг ашгийн төлөө, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг эсэхэд нь үндэслэн компани, эсхүл хуульд заасан бусад хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах” гэж өөрчлөх.

Мөн хуулийн төсөлд төрийн өмчит үйлдвэрийн газрыг төрийн өмчит компани болгон өөрчлөн байгуулах асуудлыг тухайн үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл болон санхүүгийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэх зохицуулалтыг нэмж тусгах;

5.Олон улсын туршлагаас үзэхэд, Засгийн газраас бизнесийн байгууллага болон үйлдвэрийн газарт онцгой дэглэм тогтоох асуудал нь зөвхөн төрийн өмчит компаниар хязгаарлагдахгүйгээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид ч мөн адил хэрэгжих боломжтой бөгөөд онцгой дэглэмийн үед компанийн үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах, үүссэн хүндрэлийг даван туулах, учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шинэ удирдлага томилох, ажлын байрыг хадгалах, хувьцаа, хөрөнгийн эзэмшилд хязгаарлалт тавих, стратегийн шийдвэр гаргах зэрэг эрхийг хэрэгжүүлдэг байна.

Иймд төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид онцгой дэглэм тогтоох харилцааг шинэчлэн тогтоох асуудлыг БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хамт цогцоор нь боловсруулахад анхаарах;

6.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх” гэж, 29.3 дахь хэсэгт “Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна” гэж тус тус заасны дагуу хуулийн төслийн эх бичвэрийн агуулганд тавигдах нийтлэг шаардлагыг тус тус хангах нь зүйтэй.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА /дэлгэрэнгүй/

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон, тус хөтөлбөрийн 3.1.2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.” гэж, 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж тус тус заасан.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын 6.4-т “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2023 оны тоон мэдээллээс үзэхэд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас төрийн өмчит үйлдвэрийн газар 17 байна.

Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компани хэлбэрээр байгуулна.” гэж заасан бөгөөд төр, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж болох аймаг, сум, нийслэл, дүүрэг нь иргэний эрх зүйн харилцаанд хуулийн этгээдийн нэгэн адил оролцох хуулийн зарчимтай.

Гэтэл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн зохион байгуулалт, эрх зүйн хэлбэрийг Иргэний хуулийг зөрчиж тогтоосон нь тухайн төрлийн хуулийн этгээдийн үйл ажиллагаанд үйлчилж байгаа бусад эрх зүйн зохицуулалтад хийдэл үүсэх шалтгаан болж, улмаар хууль хэрэглээний практикт төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд болон хувийн хэвшлийн хуулийн этгээдэд ялгамжтай, тэгш бус хандах нөхцөлийг бүрдүүлж байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит компаниас гадна аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой, эсхүл улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд эдгээр үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх буюу компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг байх хуулийн зохицуулалтыг бий болгох нь чухал байна.

Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газарт” гэснийг “төрийн өмчит компанид” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “төрийн өмчит компани” гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн өмчит үйлдвэрийн газраас” гэснийг “Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалтад зааснаас” гэж, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн өмчит үйлдвэрийн газрыг” гэснийг “төрийн өмчит компанийг” гэж тус тус өөрчлөх хэрэгцээ шаардлагын дагуу тус хуулийн төслийг боловсрууллаа.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 15, 16, 17, 18, 19, 20, 55 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай болон 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус дагалдуулан боловсрууллаа.

Хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэхэд түлхэц болохын зэрэгцээ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно.

Түүнчлэн хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлснээр хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах боломжийг бүрдүүлнэ.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “төрийн өмчит компани” гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн өмчит үйлдвэрийн газраас” гэснийг “Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалтад зааснаас” гэж, 22 дугаар зүйлийн “Төрийн өмчит үйлдвэрийн газар ба албан газрыг” гэснийг “Албан газрыг” гэж, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Энэ хуулийн 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар компани болон өөрчлөгдсөн төрийн өмчит үйлдвэрийн газрын” гэснийг “Төрийн өмчит” гэж, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн өмчит үйлдвэрийн газрыг” гэснийг “төрийн өмчит компанийг” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, 15, 16, 17, 18, 19, 20 дугаар зүйл, 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 55 дугаар зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компани, эсхүл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан бусад хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, дагаж мөрдсөнөөс хойш 45 хоногийн дотор үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл болон санхүүгийн үзүүлэлтэд холбогдох дүн шинжилгээ хийсний үндсэн дээр Засгийн газар холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

2 дугаар зүйл.Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компани, эсхүл Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан бусад хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг хүчин төгөлдөр дагаж мөрдсөнөөс хойш 60 хоногийн дотор үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл болон санхүүгийн үзүүлэлтэд холбогдох дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3 дугаар зүйл.Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж заасан тул Засгийн газар 2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ хийж, тайланг Монгол Улсын Их Хурлын 2027 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулна.

4 дүгээр зүйл.Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд, хувийн хэвшлийн аж ахуй нэгжид онцгой дэглэм тогтоох шаардлагатай эсэхийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсны үндсэн дээр Засгийн газар холбогдох хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ
ТАЙЛАН**

**Улаанбаатар хот
2026 он**

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Нэг.Асуудалд дүн шинжилгээ хийсэн байдал

Хоёр.Асуудлыг шийдвэрлэх зорилгыг тодорхойлсон байдал

Гурав.Асуудлыг зохицуулах хувилбарууд, эерэг, сөрөг үр дагаварт хийсэн харьцуулалт /үр дүнтэй хувилбарын тухай/

Дөрөв.Сонгосон хувилбарын үр нөлөөг тандан судалсан байдал

- хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- эдийн засагт үзүүлэх үр нөлөө
- нийгэмд үзүүлэх үр нөлөө
- байгаль орчинд үзүүлэх үр нөлөө
- Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Тав.Зөвлөмж, дүгнэлт

НЭГ.АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Төрийн болон орон нутгийн өмчийн харилцаа нь 1996 оны 05 дугаар сарын 27ны өдөр батлагдсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулагдаж байгаа бөгөөд энэ нь хувийн эрх зүйн суурь хуулиуд болсон Иргэний хууль /2002 он/, Компанийн тухай хууль /2011 он/-аас өмнө батлагдсан хууль юм.

Тус хуулийн 13 дугаар зүйлд төрийн өмчит хуулийн этгээдийг эд хөрөнгийн байдлаар нь 1/төрийн байгууллага, албан газар, 2/төрийн өмчит үйлдвэрийн газар, 3/төрийн болон орон нутгийн өмчит төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, нэгдсэн эмнэлэг, 4/төрийн болон орон нутгийн өмчийн боловсролын сургалтын байгууллага /сургуулийн өмнөх боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн болон техникийн, дээд боловсрол/ гэж ангилсан.

Мөн 15 дугаар зүйлд дээрх төрийн өмчит хуулийн этгээдийн нэг ангилал болох төрийн өмчит үйлдвэрийн газрын талаар зохицуулсан бөгөөд үүнд “Төрийн өмчит үйлдвэрийн газар гэдэгт дан ганц төрийн өмчид үндэслэсэн болон улсын төсвөөс санхүүждэг үйлдвэрийн газар орох бөгөөд тэдгээрийг эд хөрөнгийн эрхийн байдлаар нь аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилна.” гэж заасан бөгөөд “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар”, “Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар” гэж ойлгохоор тайлбарлажээ.

Ийнхүү төрийн өмчит хуулийн этгээд гэдэгт төрийн өмчит үйлдвэрийн газрын оруулж, төрийн өмчит үйлдвэрийн газрыг 1/аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар, 2/улсын төсөвт үйлдвэрийн газар гэж ангилсан нь өмчийн эрхийн суурь хууль болсон Иргэний хуулийн 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт “Ашгийн төлөө хуулийн этгээдийг нөхөрлөл, компани хэлбэрээр байгуулна.” гэж заасанд нийцэхгүй байгаа бөгөөд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчит үйлдвэрийн газрын засаглал, удирдлага, хяналт, эд хөрөнгийн эрх нь ямар байхыг заагаагүй тул хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын эрх, үүргийн ялгаа, ногдол ашиг хуваарилахын төлөө ажиллах эсэх зэрэг чухал асуудлууд тодорхой бус байгаа нь асуудал үүсгэж байна. Түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчит компанийн удирдлагыг хэрэгжүүлэхэд үр ашиггүй зардал гаргахгүй байх, мэргэжлийн байх, санхүүгийн төлөвлөгөөний дагуу ажиллах, хариуцлага, эрх, үүргийн хувьд бие даасан байх зарчмыг хангах чухал байхад дээрх зарчим нь төрийн өмчит үйлдвэрийн газарт үйлчлэх эсэх нь тодорхойгүй байна.

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас гаргасан 2023 оны тоон мэдээллээс үзэхэд, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд 99 байгаагаас төрийн өмчит үйлдвэрийн газар 17 байгаа бөгөөд орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өрхийн эмнэлэг, эм эргэлтийн сан, нөхөрлөл, аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрууд зэргийг багтааж тооцвол төрийн

болон орон нутгийн өмчийн нийт 472 хуулийн этгээд байна.¹ Үүний нэг нь тухайлбал “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрууд нь ашгийн төлөө эсэх, алдагдалгүй ажиллах хөшүүрэгтэй эсэх, хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг хуваарилах зорилготой эсэх, хуулийн этгээдийн үйл ажиллагааг олон улсын сайн туршлагад үндэслэн бие даасан байдлыг сайжруулах эрмэлзэлтэй эсэх нь тодорхойгүй байгаа тул төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газруудын бодит байдал нь зарим талаараа төрийн байгууллага, төрийн албатай адил шинжтэй, удирдлагын томилгоо нь бизнесийн төлөвлөгөө, мэргэжил, ур чадварт үндэслэсэн бус улс төрөөс улам хамааралтай болсоор байна.

Цаашид төр, орон нутаг хувьцаа эзэмшигчийн эрхийг ард түмнийг төлөөлөн хэрэгжүүлж байгаагийн хувьд энэхүү онцлог байдалд нь нийцсэн, ил тод, хяналттай, эдийн засгийг зохицуулагчийн чиг үүргээ хувьцаа эзэмшигчийн чиг үүргээсээ салангид хэрэгжүүлэх боломжийг олгосон эрх зүйн зохицуулалтыг бий болгож, компанийн эрх зүйгээр тогтсон хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын бүрэн эрх, ажил үүргийн хуваарь, хяналтын эрхийг тодруулах шаардлагатай байна.

Төрийн болон орон нутгийн өмчит компани хариуцлага, эрх, үүргийн хувьд улс төрийн нөлөөллөөс ангид, хараат бус байх, үр ашигтай байх, хараат бус хөндлөнгийн хяналттай байх, компанийн үйл ажиллагаа ил тод байх, компани төр, эсхүл орон нутгийн хүлээх үүргийг хариуцахгүй байх зарчмыг хуульчлах шаардлага үүссэн байна.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд удаа дараа хэрэглэгдсэн 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийн 1 дүгээр зүйлд “Улсын эдийн засгийн амьдрал, хүн амын үйлчилгээний хэвийн нөхцөлийг хангахад нэн чухал үүрэг бүхий тодорхой үйлдвэрийн газар, байгууллагад шаардлагатай гэж үзвэл нийтлэг баримталдаг хууль тогтоомжийн заалтыг хэрэглэхгүйгээр 6 сар хүртэл хугацаагаар тусад нь онцгой дэглэм тогтоож, харъяалал харгалзахгүйгээр өөрийн шууд хяналтад авч ажиллуулах эрхийг БНМАУ-ын Засгийн газарт олгосугай.” гэж дагуу төрийн өмчит болон орон нутгийн өмчит компанид /хувийн өмчийн оролцоотой байхад нь ч хамаагүй/ бүрэн эрхт төлөөлөгч томилдог болсон практикийг халах нь зүйтэй байна. Учир нь тус хуулийн 2 дугаар зүйлд бүрэн эрхт төлөөлөгчийн эрхийг заасан бөгөөд үүний дотор компанийн удирдлагуудыг солих, ажилтнуудын цалингийн хэмжээг өөрчлөх, үндсэн ба эргэлтийн хөрөнгөд тусгай хяналт тавих, гэрээнүүдийг цуцлах зэрэг байгууллагын дотоод үйл ажиллагаа, зохион байгуулалтад хэтэрхий халдсан эрхийг эдэлж болохоор байна. Энэ нь хуулийн этгээдийн үйл ажиллагааны бие даасан байдал болон төрийн зохицуулах чиг үүргийн заагийг бүдэгрүүлж байгаа юм.

Мөн төр хуулийн этгээдэд дуртай цагтаа өөрийн үзэмжээр бүрэн эрхт төлөөлөгч томилох нь хувийн хэвшлийнхэнд таагүй сэтгэгдэл төрүүлэх бөгөөд төрийн, эсхүл орон нутгийн өмчийн компанид хөрөнгө оруулахыг эрсдэлтэй гэж үзэн хувьцааг нь худалдан

¹ Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал. Засгийн газрын боловсруулж 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр өргөн мэдүүлсэн.

авахаас татгалзах шалтгааныг үүсгэж, тухайн компанид хохирол учруулж болохоор байна. Төр заавал бүрэн эрхт төлөөлөгч томилохгүйгээр хуулийн этгээдийн үйл

ажиллагааг хуулиудад заасан төрөл бүрийн төрийн хяналт шалгалтын арга хэлбэрээр шалгах, мэдээлэл авах, шаардлагатай бол шийтгэх бүрэн боломжтой юм.

Иймд 1992 онд Монгол Улсын Үндсэн хууль батлагдахаас өмнө батлагдсан, БНМАУ-ын үеийн хуулийг хэрэглэж, хувийн өмчийг хамгаалах, зах зээлийн эдийн засгийн зарчимд нийцдэггүй зохицуулалт буюу аж ахуйн нэгжид бүрэн эрхт төлөөлөгч томилохыг зөвшөөрсөн хуулийг хүчингүй болгох шаардлагатай байна.

ХОЁР.АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна.” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Төр нь үндэсний эдийн засгийн аюулгүй байдал, аж ахуйн бүх хэвшлийн болон хүн амын нийгмийн хөгжлийг хангах зорилгод нийцүүлэн эдийн засгийг зохицуулна.” гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан нь төрөөс нийтийн болон хувийн өмчийн хуулийн этгээдийг зохицуулахад баримтлах үндсэн зарчим болох юм.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулах зорилтыг тэргүүлэх чиглэл болгон, тус хөтөлбөрийн 3.1.2.4-т “Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлнэ.” гэж, 4.1.4.2-т “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагын нэгдмэл байдлыг хангах, төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэх...” гэж тус тус заасан. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ийн 6.4-т “Төрийн өмчит аж ахуйн нэгжүүдийн үр ашиг, засаглалыг сайжруулж, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлыг зохион байгуулна.” гэж заасан.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн дагуу төрийн болон орон нутгийн өмчит компаниас гадна аж ахуйн шинжтэй үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн тооцоотой, эсхүл улсын төсвөөс санхүүждэг төсөвт үйлдвэрийн газар хэлбэртэй хуулийн этгээд байгуулагдаж, үйл ажиллагаагаа явуулдаг болсон нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжгүй, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Иймд:

1/төрийн өмчит үйлдвэрийн газрыг зохицуулах эрх зүйн зохицуулалт тодорхойгүй байгааг цаг алдалгүй шийдвэрлэх буюу компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг болгох нь чухал байна.

2/дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг зааж, тэрхүү хугацааны дотор өөрчлөн байгуулагдахыг шахаж, хуулийн хэрэгжилтийг хангуулах шаардлагатай.

3/1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болгох шаардлагатай байна.

ГУРАВ.АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ЭЭРЭГ, СӨРӨГ ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ХАРЬЦУУЛАЛТ

Асуудлуудыг шийдвэрлэх хувилбаруудыг тус бүрээр авч үзвэл:

Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
“Тэг” хувилбар	Асуудал шийдвэрлэгдэхгүй	зорилгод хүрэх боломжгүй
Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	зорилгод хүрэх боломжгүй
Зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй	зорилгод хүрэх боломжгүй
Төрөөс санхүүгийн Интервенц хийх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй
Төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүрэг гүйцэтгүүлэх	Асуудлыг шийдвэрлэхтэй холбоогүй тул зорилгод хүрэх боломжгүй. Зардал, үр өгөөж тооцох боломжгүй.	зорилгод хүрэх боломжгүй
Захиргааны шийдвэр гаргах	Үр дүнгүй. Холбогдох хуульд өөрчлөлт оруулах, хуулийг хүчингүй болгох байдлаар шийдвэрлэгдэх боломж бүрдэнэ.	зорилгод хүрэх боломжгүй
Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Иргэний хуульд нийцүүлэх замаар л асуудлыг шийдвэрлэх боломжтой. Мөн 1991 оны хуулийг хүчингүй болгосноор л Засгийн газар бүрэн эрхт төлөөлөгч томилохыг бүрмөсөн зогсоох боломжтой.	Үр дүнтэй

Дээрх хувилбаруудыг харьцуулан үзэхэд “тэг” хувилбар буюу ямар нэг арга хэмжээг авахгүй байх, одоо байгаа нөхцөл байдлыг хэвээр үлдээх нь төрийн болон орон нутгийн өмчийн хуулийн этгээдийг өөрчлөгдөхөд хүргэхгүй юм.

Хэвлэл мэдээлэл болон бусад арга хэрэгслээр дамжуулан олон нийтийг соён гэгээрүүлэх, зах зээлийн механизмаар дамжуулан төрөөс зохицуулалт хийх, төрөөс санхүүгийн интервенц хийх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх зэрэг арга хэмжээ буюу тухайлбал, одоогийн хүчин төгөлдөр

дагаж мөрдөж буй хууль эрх зүйн баримт бичгийн хүрээнд тодорхой арга хэмжээ авч болох ч зорилгод хүрэх боломж хязгаарлагдмал хэвээр байхаар байна.

Төрийн өмчит үйлдвэрийн газар, түүний төрлүүдийг хуулиар тодорхойлсон тул тус Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийг Иргэний хуульд нийцүүлэх замаар л төрийн болон орон нутгийн өмчийн үйлдвэрийн газрууд хуулийн этгээдийн хэлбэрээ өөрчилж, өөрчлөн байгуулагдах ба 1991 оны “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хуулиар хүчингүй болгосноор л Засгийн газар энэ хуулийг ашиглаж дахин бүрэн эрхт төлөөлөгч томилохыг бүрмөсөн зогсоох боломжтой.

Иймд дээр дэвшүүлсэн асуудлыг хуулийн төсөл боловсруулах замаар шийдвэрлэх нь үр дүнтэй байна.

ДӨРӨВ.СОНГОСОН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Хэдийгээр Засгийн газар Нийтийн өмчийн тухай хуулийн төсөл болон Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай хуулийн төслийг боловсруулж, 2025 онд Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн боловч тус хуулийн төслүүд одоогоор зөвхөн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжиж, тус хуулийг хэлэлцүүлэгт бэлтгэх Ажлын хэсэг байгуулах шатанд очсон байна. Эдгээр хуулийн төслүүд нь төрийн болон орон нутгийн өмчийн суурь хуулиуд бөгөөд онолын, хууль зүйн, практикийн чухал ач холбогдолтой тул олон удаагийн олон нийтийн болон мэргэжилтнүүдийн хэлэлцүүлэг, тооцоо, судалгаа, зөвшилцлийн дүнд батлагдах нь тодорхой юм. Иймд эдгээр хуулиуд хэдийгээр аль хэдийнэ өргөн мэдүүлэгдсэн боловч батлагдах, үйлчилж эхлэх хүртэл хугацаа шаардах нь ойлгомжтой байна.

Харин энэ хооронд төрийн өмчит компаниуд өмчийн хэлбэрээ өөрчлөн зохион байгуулагдаж, засаглалын шинэчлэл хийж байх боломжтой байна.

Хуулийн төсөлд тусгах зохицуулалтад хүний эрхийг хязгаарласан, сөрөг нөлөө үзүүлэх агуулга байхгүй болно. Мөн Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцэх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа бусад хууль тогтоомжтой зөрчилдөхгүй болно.

ТАВ.ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

Хуулийн этгээдийн өмчийн хэлбэр бол тухайн байгууллагын нэрний нэг хэсэг болохоос гадна тус хуулийн этгээдийн өмчийн хэлбэр, засаглалын хэлбэр, зохион байгуулалт, удирдлагын арга, удирдах этгээдүүдийн эрх, үүрэг, тухайн хуулийн этгээд татан буугдах, дампуурахад авах арга хэмжээ, хувьцаа эзэмшигч, удирдлагаасаа тусдаа бие даасан өмч зэрэг олон шинж чанарыг тодорхой болгодог. Иймд хуулийн этгээдийн аль хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулахаа сонгох нь маш ач холбогдолтой шийдвэр юм.

Гэтэл 1996 оны Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд Иргэний хуульд байхгүй төрлийн хуулийн этгээд буюу төрийн өмчит үйлдвэрийн газар /үүнд, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар, улсын төсөвт үйлдвэрийн газар/ гэсэн хуулийн этгээд

байгуулахаар зааж байгуулсан нь аль төрлийн хуулийн этгээд болох нь ойлгомжгүй нөхцөл байдал үүсгэсэн.

Иймд хуулийн төсөл боловсруулж дараах арга хэмжээг авах шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

1/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулж төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг болгох;
2/дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг зааж, тэрхүү хугацааны дотор өөрчлөн байгуулагдахыг шахаж, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах;

3/"Хууль хүчингүй болгох тухай" хуулийн төсөл боловсруулж, 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан "БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай" хуулийг хүчингүй болгох.

---o0o---

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын зорилт нь боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлж, хуулийн төслийн давхардал, хийдэл, зөрчлийг арилган хуулийг хэрэглэхэд ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулах, улмаар хуулийн төслийн чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмж өгөхөд оршино.

1. “Зорилгод хүрэх байдал”

Улсын Их Хурлаас 1996 онд баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нийт 39 удаа нэмэлт, өөрчлөлт орсон буюу хуулийн 80 орчим хувь нь өөрчлөгдсөн байна. Энэ удаагийн өөрчлөлтөөр дараах 3 асуудлыг шийдвэрлэхээр зорьсон тухай хуулийн төслийн үзэл баримтлалд дурдсан байна. Үүнд:

1/“Хуулийн төсөл батлагдсанаар төрийн болон орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийг улс төрөөс хараат бус, нээлттэй, ил тод, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоог бүрдүүлэхэд түлхэц болохын зэрэгцээ төрийн болон орон нутгийн өмчит компаниудын засаглал, ил тод байдлыг сайжруулж, олон улсын менежментийн багаар удирдуулж, нээлттэй хувьцаат компани болгон, үр ашиг, баялгийн тэгш хуваарилалтыг нэмэгдүүлэхэд чухал алхам болно.”

2/“... хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлэх нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах боломжийг бүрдүүлнэ.” гэж тусгасан байна.

3/“Хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, олон улсын жишиг хандлагыг баримтлан компанийн сайн засаглалыг бүрдүүлэх шаардлагын үүднээс 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийн дагуу төрийн өмчит компанид бүрэн эрхт төлөөлөгч томилдог байдлыг халах нь зүйтэй байна.” гэжээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр дараах асуудлыг зохицуулахаар тусгасан нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, компанийн сайн засаглалыг бүрдүүлэх зорилгод нийцэж байна:

1/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулж төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг болгох;
2/дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг зааж, тэрхүү хугацааны дотор өөрчлөн

байгуулагдахыг шахаж, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах;

3/“Хууль хүчингүй болгох тухай” хуулийн төсөл боловсруулж, 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болгох.

Шалгуур үзүүлэлт	Үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл	Үнэлэх	Дүгнэх
Зорилгод хүрэх байдал	1/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулж төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг болгох;	Зорилгод дүн шинжилгээ хийх	Үр нөлөөг үнэлэх	Дүгнэлт гаргах
Хүлээн зөвшөөрөгдөх байдал	2/дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг зааж, тэрхүү хугацааны дотор өөрчлөн байгуулагдахыг шахаж, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах;	Хүлээн зөвшөөрөгдөх байдлыг судлах	Хэрэгжүүлэх этгээдүүд хүлээн зөвшөөрөх, бүтэц зохион байгуулалт тодорхой эсэхийг үнэлэх	
Харилцан уялдаа	3/“Хууль хүчингүй болгох тухай” хуулийн төсөл боловсруулж, 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болгох.	Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах	Хуулийн төсөл боловсруулах шаардлагад нийцсэн эсэхийг шалгах	

2. “Хүлээн зөвшөөрөгдөх байдал”

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд төрийн өмчит үйлдвэрийн газрыг тус хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 45 хоногийн дотор компани болгон өөрчлөн байгуулахыг, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын компани, эсхүл бусад хуулийн этгээдийн хэлбэрээр тус хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгахыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд даалгажээ. Иймд

тус хуулийг хэрэгжүүлэх этгээд хэн байх, ямар хугацаанд, яаж хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрэх нь тодорхой байна.

3. “Хуулийн төслийн уялдаа холбоог шалгах” шалгах хэрэгслийн хүрээнд дараах асуултад хариулах замаар хуулийн төслийн уялдаа холбоог тогтоов:

- хуулийн төслийн зохицуулалт тухайн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн зорилттой нийцэж байх бөгөөд хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь төрийн болон орон нутгийн өмчийн эрх, төрийн өмчийн эд хөрөнгийн талаар хууль тогтоох, гүйцэтгэх байгууллагын бүрэн эрх, төрийн өмчтэй хуулийн этгээд, түүний албан тушаалтны эрх хэмжээ, төрийн өмчийн талаархи бодлогыг хэрэгжүүлэх байгууллагын үйл ажиллагааны зарчим, журмыг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.” гэж заасантай харшлах зүйлгүй байна.
- Харин хуулийн төслийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг хүчингүй болгож, “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “төрийн өмчийн компани” болгож өөрчилсөн хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчит үйлдвэрийн газрын төрөл болох “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”, “улсын төсөвт үйлдвэрийн газар” гэснийг үлдээсэн нь тодорхойгүй байдал үүсгэж болохоор байна. Учир нь хэдийгээр төрийн өмчит үйлдвэрийн газар нь дотроо дээрх хоёр нэр томъёог агуулдаг боловч практикт хуулийн этгээдийн улсын бүртгэлд “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”, “улсын төсөвт үйлдвэрийн газар” гэсэн хэлбэрээр эдгээр хуулийн этгээдүүд бүртгэгддэг тул компани болгон өөрчлөн байгуулагдах ёстой гэж ойлгохгүй байх магадлалтай байна. Түүнчлэн хуулийн бусад зүйлүүдэд “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”, “улсын төсөвт үйлдвэрийн газар” гэсэн нэр томъёо хэвээрээ үлдсэн нь ийм төрлийн хуулийн этгээд байгаа гэж үзэх үндэслэлийг улам баталгаажуулж байгаа тул үүнийг нэг мөр жигдэлж, хийдэл, ойлгомжгүй байдал үүсгэхгүй байх шаардлагатай. Үүнийг эс тооцвол хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа болно;
- хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан зохицуулалт байхгүй болно;
- хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээд хэн байхыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд тодорхой заасан болно;
- хуулийн төсөлд орхигдуулсан зохицуулалт байхгүй болно;
- хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан зохицуулалт байхгүй;

- төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжгүй гэдэг нь тандан судалгаагаар тогтоогдсон;
- татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон зохицуулалт байхгүй;
- тухайн хуулийн төсөлд тусгасан зөвшөөрөлтэй холбоотой зохицуулалт байхгүй;
- Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгаагүй;
- хуулийн төслийн зүйл, заалт жендэрийн эрх тэгш байдлыг хангасан;
- хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй;
- хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдаагүй;
- хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тусгах шаардлагагүй;
- тухайн хуулийн төсөлд хамаарах этгээдүүдээс санал дүгнэлт авч, хуулийн төсөл, түүний зохицуулалтыг нэг мөр ойлгож, хэрэгжүүлэх боломжтой.

ДҮГНЭЛТ

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль болон дагалдуулан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль болон Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулиар дараах асуудлуудыг шийдэхийг зорьсон байна:

1/ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулж төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг болгох;

2/дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг зааж, тэрхүү хугацааны дотор өөрчлөн байгуулагдахыг шахаж, хуулийн хэрэгжилтийг хангуулахаар дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөл боловсруулах;.

3/“Хууль хүчингүй болгох тухай” хуулийн төсөл боловсруулж, 1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болгох.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөр дараах асуудлыг зохицуулахаар тусгасан нь хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, хөгжлийн бодлого төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг хангах, компанийн сайн засаглалыг бүрдүүлэх зорилгод нийцэж байна

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төсөлд төрийн өмчит үйлдвэрийн газрыг тус хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 45 хоногийн дотор компани болгон өөрчлөн байгуулахыг, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын компани, эсхүл бусад хуулийн этгээдийн хэлбэрээр тус хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 60 хоногийн дотор өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгахыг тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд даалгажээ. Иймд тус хуулийг хэрэгжүүлэх этгээд хэн байх, ямар хугацаанд, яаж хэрэгжүүлж, ямар үр дүнд хүрэх нь тодорхой байна.

Хуулийн төслийн зүйл, заалт өөр хоорондоо болон хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой нийцсэн, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн зохицуулалт байхгүй байна. Гэхдээ хуулийн төслийн дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг хүчингүй болгож, “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “төрийн өмчийн компани” болгож өөрчилсөн хэдий ч Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд төрийн өмчит үйлдвэрийн газрын төрөл болох “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”, “улсын төсөвт үйлдвэрийн газар” гэсэн нэр томъёог хэвээр үлдээсэн нь тодорхойгүй байдал үүсгэж болохоор байгаа тул “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”, “улсын төсөвт үйлдвэрийн газар” гэсэн нэр томъёо нэг мөр жигдэлж, энэ хэлбэрээр байгуулагдсан хуулийн этгээдүүд компанийн хэлбэрт орж, өөрчлөн байгуулагдахгүй үлдэж, хийдэл, ойлгомжгүй байдал үүсэж болзошгүйг анхаарч, засах шаардлагатай;

Хуулийн төслийг боловсруулахдаа Хууль тогтоомжийн тухай хууль болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан байна гэж үзлээ.

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ХИЙСЭН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/-ийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу шалгаж үзвэл:

1.Иргэнд үүсэх зардлыг цаг хугацааны болон шууд бий болох мөнгөн зардал гэсэн үзүүлэлтээр нэг жилд бий болох зардлыг тооцож гаргадаг бөгөөд хуулийн төсөлд иргэнд ямар нэг үүрэг шинээр оноосон заалт байхгүй тул түүнд зарцуулах хугацаа, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардал үүсэхгүй болно.

2.Хуулийн этгээдэд нэг жилд бий болох хүний нөөцийн болон мөнгөн зардлыг тооцдог бөгөөд тус хуулийн төслөөр хуулийн этгээдэд үүрэг болгосон зохицуулалт байхгүй тул хүний нөөц шинээр бий болох, түүнтэй холбоотой мөнгөн зардал үүсэхээргүй байна.

3.Төрийн байгууллагад хүний нөөц шинээр болох, шинэ бүтэц бий болохтой холбоотой зардлыг нэг жилээр тооцож гаргах бөгөөд хуулийн төслийн зохицуулалтаас харахад шинээр орон тоо нэмэх, бүтэц бий болгохоор хэмжээний үүрэг нэмээгүй буюу 17 төрийн өмчийн үйлдвэрийн газрыг компани болгон өөрчлөн байгуулах ажил байгаа тул ийм төрлийн зардал бий болохгүй гэж үзэж байна.

Хуулийн төсөлд дараах зохицуулалтууд туссан. Үүнд:


1/төрийн өмчит үйлдвэрийн газрыг компанийн хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг болгох,

2/дээрх зохицуулалтыг хэрэгжүүлэх хугацааг зааж, тэрхүү хугацааны дотор өөрчлөн байгуулагдахыг шаардах,

3/1991 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай” хуулийг хүчингүй болгох.

Иймд иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад цаг хугацааны, хүний нөөцийн, мөнгөн зардал бий болохооргүй байна.

Хууль санаачлагч нар



УИХ-ын гишүүн
Пүрэвжавын САЙНЗОРИГ



УИХ-ын гишүүн
Аюушийн АРИУНЗАЯА

Боловсруулж буй

Өргөн баригдсан

Хэлэлцэх эс:

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ


2025 ОНЫ 10-Р САРЫН 31 ӨДӨРУЛААНБААТАР

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ



✓ Дагах

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1

 хэсгийн 2 дахь заалтын "төрийн өмчит үйлдвэрийн газарт" гэснийг "төрийн өмчит компанил" гэж 13 лугаар зүйлийн 2 ляхь

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газарт” гэснийг “төрийн өмчит компанид” гэж, 13 дугаар зүйлийн 2 дахь заалтын “төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “төрийн өмчит компани” гэж, 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Төрийн өмчит үйлдвэрийн газраас” гэснийг “Энэ хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь заалтад зааснаас” гэж, 22 дугаар зүйлийн “Төрийн өмчит үйлдвэрийн газар” гэснийг “Төрийн өмчит компани” гэж, 56 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Энэ хуулийн 55 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар компани болон өөрчлөгдсөн төрийн өмчит үйлдвэрийн газрын” гэснийг “Төрийн өмчийн” гэж, 60 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “төрийн өмчит үйлдвэрийн газрыг” гэснийг “төрийн өмчит компанийг” гэж тус тус өөрчилсүгэй.



2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15, 55 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.



**ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ хуулийн төсөлд ирүүлсэн саналын товъёог**

	Байгууллага, албан бичиг, огноо	Санал	Саналыг тусгасан байдал
1.	Монгол Улсын Засгийн газар 2026.01.15 ХЭГ/155	<p>1.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 4, 5 дугаар зүйлд тус тус зааснаар төрийн өмчийг төрийн нийтийн зориулалттай өмч, төрийн өөрийн өмч гэж ангилах бөгөөд төрийн өөрийн өмчид мөн хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3-т зааснаар төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төрд ногдох хувь хөрөнгө буюу төрийн өмчит компанийн төрд ногдох хувь хөрөнгө хамаардаг. Харин Монгол Улсын Засгийн газраас 2025 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн өмчийн хуулийн төсөл (Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл)-ийн 7 дугаар зүйлд төрийн өмч нь төрийн нийтийн болон тусгайлсан өмчөөс бүрдэхээр, 8 дугаар зүйлийн 8.1.11 дэх заалтад стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нь төрийн нийтийн өмч байхаар, 9 дүгээр зүйлийн 9.1.7 дахы заалтад стратегийн ач холбогдол бүхий салбарт үйл ажиллагаа явуулж байгаагаас бусад төрийн өмчит компанийн төрийн эзэмшлийн хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаас нь төрийн тусгайлсан өмч байхаар тус тус заасан. Өөрөөр хэлбэл, төрийн өмчит компанийн эд хөрөнгө нь төрийн өмчид хамаарахгүй бөгөөд төр зөвхөн хувьцаа эзэмшигчийн эрх, үүргийн хүрээнд уг компанийн үйл ажиллагаанд оролцохоор тусгасан. Харин Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд төрийн өөрийн өмчийн төрлийн нэг болох Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан "төрийн өмчит үйлдвэрийн газарт" эзэмшүүлсэн эд хөрөнгө гэснийг "төрийн өмчит компанид" эзэмшүүлсэн эд хөрөнгө болгон өөрчлөхөөр тусгасан нь төр хувьцаа эзэмшигчээс гадна өмчлөгчийн хувьд төрийн өмчит компанийн эд хөрөнгийг удирдах боломжийг бүрдүүлж байх тул уг хэсгийг хасах;</p>	2025.10.31-ний өдөр УИХ-03/12459 дугаартай албан бичгээр санал авахаар хүргүүлсэн.

2.Хуулийн төсөлд “улсын төсөвт үйлдвэрийн газар”, “аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар” зэрэг төрийн өмчит үйлдвэрийн газрын ангиллыг хуульчилсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 15 дугаар зүйлийг бүхэлд нь хүчингүй болгохоор тусгасан боловч мөн хуулийн 16 дугаар зүйл “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх”, 17 дугаар зүйл “Улсын төсөвт үйлдвэрийн газрын эд хөрөнгийн эрх”, 18 дугаар зүйл “Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газрын захиргаа” гэсэн зохицуулалтыг хэвээр үлдээсэн байгааг анхаарах; 3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13 дугаар зүйлд төрийн өмчит хуулийн этгээдийн ангилалд төрийн байгууллага, албан газар, төрийн өмчит үйлдвэрийн газар хамаарахаар, мөн хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт төрийн өмчийн хувьцаатай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд гэж ойлгохоор тус тус заасан тул төрийн өмчит компани нь төрийн өмчит хуулийн этгээд бус харин төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд болно. Иймд Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 13, 22 дугаар зүйлд заасан төрийн өмчит хуулийн этгээдийн ангилал, тэдгээрийг байгуулах зохицуулалтад “төрийн өмчит компани” буюу төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийг нэмэхээр тусгасан нь үндэслэлгүй байна;

4.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд төрийн өмчит үйлдвэрийн газрыг компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг шийдвэрлэхээр тусгасан нь улс орныг хамарсан, нийгмийн хэрэгцээг хангах зорилготой, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг төрийн өмчит үйлдвэрийн газрууд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулах зайлшгүй шаардлага үүсэж, төрөөс хүн, хуулийн этгээдэд чиглэсэн үйлчилгээнүүд төлбөртэй болох зэрэг эрсдэлтэй байна. Иймд тус хуулийн төслийн 1 дүгээр зүйлд “Төрийн өмчит үйлдвэрийн газрыг компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах” гэснийг “Төрийн өмчит үйлдвэрийн газрыг ашгийн төлөө, ашгийн бус үйл ажиллагаа явуулдаг эсэхэд нь үндэслэн компани, эсхүл хуульд заасан бусад хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах” гэж өөрчлөх. Мөн хуулийн төсөлд төрийн

өмчит үйлдвэрийн газрыг төрийн өмчит компани болгон өөрчлөн байгуулах асуудлыг тухайн үйлдвэрийн газрын үйл ажиллагааны чиглэл болон санхүүгийн үзүүлэлтэд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр шийдвэрлэх зохицуулалтыг нэмж тусгах;

5.Олон улсын туршлагаас үзэхэд, Засгийн газраас бизнесийн байгууллага болон үйлдвэрийн газарт онцгой дэглэм тогтоох асуудал нь зөвхөн төрийн өмчит компаниар хязгаарлагдахгүйгээр хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид ч мөн адил хэрэгжих боломжтой бөгөөд онцгой дэглэмийн үед компанийн үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулах, үүссэн хүндрэлийг даван туулах, учирч болзошгүй хохирлоос урьдчилан сэргийлэх зорилгоор төрөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэх, шинэ удирдлага томилох, ажлын байрыг хадгалах, хувьцаа, хөрөнгийн эзэмшилд хязгаарлалт тавих, стратегийн шийдвэр гаргах зэрэг эрхийг хэрэгжүүлдэг байна. Иймд төрийн өмчит болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгжид онцгой дэглэм тогтоох харилцааг шинэчлэн тогтоох асуудлыг БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийн хамт цогцоор нь боловсруулахад анхаарах;

6.Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад "тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх" гэж, 29.3 дахь хэсэгт "Шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна" гэж тус тус заасны дагуу хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавигдах нийтлэг шаардлагыг тус тус хангах нь зүйтэй." гэжээ.

2.	<p>Монголын үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим</p> <p>2025.11.13</p> <p>01/1064</p>	<p>Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд Монгол Улс нийтийн ба хувийн өмчид тулгуурласан олон хэвшил бүхий эдийн засгийн тогтолцоотой байх нь нийгмийн байгууллын нэгэн үндэс байх талаар хуульчилсан бөгөөд энэ үндэслэлийн дагуу Монгол Улсад оршиж байгаа өмчийн төрлүүдийг, тэр дундаа төрийн өмчийн харилцааг ул үндэстэйгээр, онолын түвшинд дахин сайтар авч үзэх төдийгүй үзэл баримтлал, салбар хуулиудыг тодорхой болгох шаардлага үүсгэж байгаатай санал нэг байна. Гэвч эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтыг Үндсэн хуулиар баталгаажуулсан төрийн эдийн засгийн харилцааны зохицуулах ба оролцох гэсэн үндсэн хоёр чиг үүргийг ялгаж хуульчлах зүй ёсны асуудал нь та бүхний санаачлан боловсруулж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдаагүй байгаа нь төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоо бүрдэх нөхцөл хангагдахгүй байх эрсдэлтэй болно. Өөрөөр хэлбэл төрийн нийтийн өмч, өөрийн өмч гэх ойлголтын өөрийн өмчид хамаарах өмчийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулж байгаа бол төрийн нийтийн хамааралтай өмчид хамаарах харилцааг хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байгаа болно. Төрийн нийтийн өмчийн хамаарах хуулийн зохицуулалтыг бий болгоогүйгээс шалтгаалан хэн эзэмших, захиран зарцуулах нь хуульчлагдаагүй нөхцөл байдалд хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлж өөрчлөх нь төрийн нийтийн өмчийг эзэмшиж, ашиглаж байгаа төрийн өмчит зарим компаниуд газрын хэвлийн баялгийг улсын нөөцийн санд оруулж байгаа ч өөрсдөдөө актив хөрөнгө болгох боломж бүрдэхгүй буюу эргээд зах зээлийн шударга, өрсөлдөөнд оролцох боломжийг олгохгүй юм. Иймд, тус хуулийн төсөлтэй холбогдох саналыг үзэл баримтлалын хүрээнд буюу төрийн нийтийн хамааралтай өмчийн асуудлыг шинээр шийдэх эрх зүйн орчин бүрдүүлэх өргөн хүрээний судлагаа, шинжилгээ шаардлагатай байна. Түүнчлэн, 1991 онд батлагдсан БНМАУ-ын</p>	Дэмжсэн.
----	---	--	----------

Засгийн газарт эрх олгох тухай хууль нь улс орны эдийн засгийн байдлыг тогтворжуулах шаардлагатай шуурхай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлж байх, болзошгүй сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгыг агуулсан бөгөөд өнөөдрийн нийгэм, эдийн засгийн хүрээнд үүсэж буй эрх зүйн харилцааг зохицуулахад нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, зохицуулалтын зорилго, арга хэлбэрт нийцэхгүй байх тул тус хуулийг хүчингүй болгохыг дэмжиж байна. Харин төрөөс өөрийн болон нийтийн өмчдөө хамаарах хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замаар өрсөлдөөний зарчмаар хувийн хэвшил бие даан гүйцэтгэх боломжтой салбарт төр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхгүй байж, тухайн салбарыг чөлөөт зах зээлийн зарчмаар хөгжих боломжийг хангах ба зах зээл дэх төрийн оролцоог багасгаж, олон улсын стандарт, зохицуулалт, шаардлагыг хангасан мэргэжлийн удирдлага, багийн нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмыг бий болгосноор тухайн салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тариф зах зээлийн өрсөлдөөний зарчмаар тогтох зэрэг эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх юм. Ингэснээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэх боломжтой юм. Цаашид төрийн өмчит компани, аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд дан ганц Бүрэн эрхт төлөөлөгч томилох асуудлаас гадна засаглалын хувьд анхаарах зайлшгүй шаардлага байгааг анхаарч НҮБ, ЭЗХАБ, ОУБ-уудын Сайн засаглалын зарчим, стандарт, удирдамжуудыг баримтлах зарчмыг тусгасан хууль тогтоомжийг батлах нь эрх бүхий байгууллагын үүрэг мөн тул анхааралдаа авахыг хүсье. Тухайлбал, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ)-ээс Монгол улсын уул уурхайн засаглал бага зэрэг сайжирсан боловч олон нийтэд мэдээлэл хүргэх байдал болон Төрийн өмчит компаниуд засаглалын хувьд анхаарах шаардлагатай байгааг 2021 оны Баялгийн засаглалын индекс (БЗИ)-ийн үзүүлэлтээр тодорхойлсон бөгөөд Монгол Улс нь "Төрийн өмчит компанийн засаглал" үзүүлэлтээр тааруухан гүйцэтгэлтэй байна гэх дүгнэлт Олон Улсын түвшинд гарсан байна. Дээр дурдсан асуудлуудын улмаас

		<p>Төрийн өмчит компанийн засаглалтай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн №85 тоот Засгийн газрын тогтоолоор батлагдсан Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг шинэчилэх, цаашлаад яамд болон орон нутгийн эрх бүхий байгууллагаас ТУЗ-ийн гишүүдийг томилдог байдлыг эрс таслан зогсоохыг болон ногдол ашгийг төрийн өндөр дээд албан тушаалтнуудын улс төрийн оноо авах арга хэрэгсэл болгож ард түмэнд тараах үйлдлээс шалтгаалан мөнгөний ханшийн уналт гэх мэт макро эдийн засгийн түвшинд сөргөөр нөлөөлж байгаа зэргийг анхааралдаа авахыг та бүхнээс ХИЧЭЭНгүйлэн хүсье.</p>	
3.	<p>Монголын хуульчдын холбоо 2026.01.05 2/09</p>	<p>Тус хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд улсын төсөвт үйлдвэрийн газар зэрэг шинээр төрийн өмчит хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэхийг хориглох зохицуулалтыг хуулийн төсөлд нэмэх саналтай байна.</p>	<p>Дэмжсэн.</p>



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ГИШҮҮН П.САЙНЗОРИГ ТАНАА

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНТ
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУДАЛДАА
АЖ ҮЙЛДВЭРИЙН ТАНХИМ

Улаанбаатар хот, 17011, Хан-Уул дүүрэг, 15-р хороо,
М.Гандигийн гудамж, МҮХАҮТ-ын байр, УБ шуудан -101011001,
Утас: 77277070, Факс: 976-11-324620,
E-mail: chamber@mongolchamber.mn

2025 11 13 № 01/1064
танай _____ -ны № _____ -т

Санал хүргүүлэх тухай

Танд энэ өдрийн мэнд хүргэе.

Монгол Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг, Б.Баярбаатар, О.Номинчимэг, А.Ариунзаяа, Э.Болормаа, О.Саранчулуун, Ч.Номин, Х.Баасанжаргал, С.Энхцэцэг нараас боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, дагалдуулан боловсруулсан Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай, 1991 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр баталсан “БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох” хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл, холбогдох судалгаануудыг хүлээн авч танилцлаа.

Монгол Улсын Үндсэн хуулийн 5 дугаар зүйлд Монгол Улс нийтийн ба хувийн өмчид тулгуурласан олон хэвшил бүхий эдийн засгийн тогтолцоотой байх нь нийгмийн байгууллын нэгэн үндэс байх талаар хуульчилсан бөгөөд энэ үндэслэлийн дагуу Монгол Улсад оршиж байгаа өмчийн төрлүүдийг, тэр дундаа төрийн өмчийн харилцааг ул үндэстэйгээр, онолын түвшинд дахин сайтар авч үзэх төдийгүй үзэл баримтлал, салбар хуулиудыг тодорхой болгох шаардлага үүсгэж байгаатай санал нэг байна.

Гэвч эдийн засгийн харилцаан дахь төрийн зохицуулалтыг Үндсэн хуулиар баталгаажуулсан төрийн эдийн засгийн харилцааны зохицуулах ба оролцох гэсэн үндсэн хоёр чиг үүргийг ялгаж хуульчлах зүй ёсны асуудал нь та бүхний санаачлан боловсруулж буй Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдаагүй байгаа нь төрийн болон орон нутгийн өмч үнэгүйдэх, алдагдалд орох, төр болон орон нутаг үзэмжээрээ аж ахуй эрхлэх нөхцөлийг хязгаарлах, төрийн өмчит хуулийн этгээдийн засаглал ойлгомжтой болох, зах зээлийн зарчмаар үйл ажиллагаа явуулах тогтолцоо бүрдэх нөхцөл хангагдахгүй байх эрсдэлтэй болно. Өөрөөр хэлбэл төрийн нийтийн өмч, өөрийн өмч гэх ойлголтын өөрийн өмчид хамаарах өмчийн харилцааг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиар зохицуулж байгаа бол төрийн нийтийн хамааралтай өмчид хамаарах харилцааг хэрхэн зохицуулах нь тодорхойгүй байгаа болно.

Төрийн нийтийн өмчийн хамаарах хуулийн зохицуулалтыг бий болгоогүйгээс шалтгаалан хэн эзэмших, захиран зарцуулах нь хуульчлагдаагүй нөхцөл байдалд хуулийн этгээдийн хэлбэрийг Иргэний хуультай нийцүүлж өөрчлөх нь төрийн нийтийн өмчийг эзэмшиж, ашиглаж байгаа төрийн өмчит зарим компаниуд газрын хэвлийн баялгийг улсын нөөцийн санд оруулж байгаа ч өөрсдөдөө актив хөрөнгө болгох боломж бүрдэхгүй буюу эргээд зах зээлийн шударга, өрсөлдөөнд оролцох

0000069

боломжийг олгохгүй юм. Иймд, тус хуулийн төсөлтэй холбогдох саналыг үзэл баримталын хүрээнд буюу төрийн нийтийн хамааралтай өмчийн асуудлыг шинээр шийдэх эрх зүйн орчин бүрдүүлэх өргөн хүрээний судлагаа, шинжилгээ шаардлагатай байна.

Түүнчлэн, 1991 онд батлагдсан БНМАУ-ын Засгийн газарт эрх олгох тухай хууль нь улс орны эдийн засгийн байдлыг тогтворжуулах шаардлагатай шуурхай арга хэмжээг цаг тухайд нь авч хэрэгжүүлж байх, болзошгүй сөрөг үзэгдлээс урьдчилан сэргийлэх зорилгыг агуулсан бөгөөд өнөөдрийн нийгэм, эдийн засгийн хүрээнд үүсэж буй эрх зүйн харилцааг зохицуулахад нийгэм, эдийн засгийн нөхцөл байдал, зохицуулалтын зорилго, арга хэлбэрт нийцэхгүй байх тул тус хуулийг хүчингүй болгохыг дэмжиж байна.

Харин төрөөс өөрийн болон нийтийн өмчдөө хамаарах хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох арга замаар өрсөлдөөний зарчмаар хувийн хэвшил бие даан гүйцэтгэх боломжтой салбарт төр аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхгүй байж, тухайн салбарыг чөлөөт зах зээлийн зарчмаар хөгжих боломжийг хангах ба зах зээл дэх төрийн оролцоог багасгаж, олон улсын стандарт, зохицуулалт, шаардлагыг хангасан мэргэжлийн удирдлага, багийн нээлттэй сонгон шалгаруулалтын зарчмыг бий болгосноор тухайн салбарт бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ тариф зах зээлийн өрсөлдөөний зарчмаар тогтох зэрэг эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх юм. Ингэснээр Монгол Улсын эдийн засаг, нийгмийн тогтвортой хөгжлийг хангах, төрийн өмчит компанийн засаглалыг сайжруулж, үр ашгийг нэмэгдүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг олон нийтийн хяналтад оруулах, санхүүгийн сахилга бат, үйл ажиллагааны тогтвортой, ил тод байдлыг хангах зорилтыг хэрэгжүүлэх боломжтой юм.

Цаашид төрийн өмчит компани, аж ахуйн нэгж байгууллагуудын хувьд дан ганц Бүрэн эрхт төлөөлөгч томилох асуудлаас гадна засаглалын хувьд анхаарах зайлшгүй шаардлага байгааг анхаарч НҮБ, ЭЗХАБ, ОУБ-уудын Сайн засаглалын зарчим, стандарт, удирдамжуудыг баримтлах зарчмыг тусгасан хууль тогтоомжийг батлах нь эрх бүхий байгууллагын үүрэг мөн тул анхааралдаа авахыг хүсье. Тухайлбал, Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн (ББЗХ)-ээс Монгол улсын уул уурхайн засаглал бага зэрэг сайжирсан боловч олон нийтэд мэдээлэл хүргэх байдал болон Төрийн өмчит компаниуд засаглалын хувьд анхаарах шаардлагатай байгааг 2021 оны Баялгийн засаглалын индекс (БЗИ)-ийн үзүүлэлтээр тодорхойлсон бөгөөд Монгол Улс нь "Төрийн өмчит компанийн засаглал" үзүүлэлтээр тааруухан гүйцэтгэлтэй байна гэх дүгнэлт Олон Улсын түвшинд гарсан байна.

Дээр дурдсан асуудлуудын улмаас Төрийн өмчит компанийн засаглалтай холбогдуулан 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн №85 тоот Засгийн газрын тогтоолоор батлагдсан Төрийн өмчит компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүнийг сонгон шалгаруулах журмыг шинэчилэх, цаашлаад яамд болон орон нутгийн эрх бүхий байгууллагаас ТУЗ-ийн гишүүдийг томилдог байдлыг эрс таслан зогсоохыг болон ногдол ашгийг төрийн өндөр дээд албан тушаалтнуудын улс төрийн оноо авах арга хэрэгсэл болгож ард түмэнд тараах үйлдлээс шалтгаалан мөнгөний ханшийн уналт гэх мэт макро эдийн засгийн түвшинд сөргөөр нөлөөлж байгаа зэргийг анхааралдаа авахыг та бүхнээс хичээнгүйлэн хүсье.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Б.ЛХАГВАЖАВ



УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН

П.САЙНЗОРИГ ТАНАА

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН
ХОЛБОО**

15150 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
5-р хороо Хуульчдын ордон 17 давхар 1701 тоот
Монголын Хуульчдын холбооны байр
Веб: www.mglbar.mn, И-мэйл: info@mglbar.mn
Утас: 70116364, Факс: 70116364

2026.01.05 № 2/09
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Танаас 2025 оны УИХ-03/124360 дугаартай албан бичгээр ирүүлсэн Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцлаа.

Тус хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд улсын төсөвт үйлдвэрийн газар зэрэг шинээр төрийн өмчит хуулийн этгээдийн төрөл, хэлбэрийг нэмэгдүүлэхийг хориглох зохицуулалтыг хуулийн төсөлд нэмэх саналтай байна.

ЕРӨНХИЙЛӨГЧ



М.МӨНХБАТ